



**MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1**  
**MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1**  
**MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1**

Monday 19 May 2003 (morning)

Lundi 19 mai 2003 (matin)

Lunes 19 de mayo de 2003 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

---

**INSTRUCTIONS TO CANDIDATES**

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.

**INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS**

- Ne pas ouvrir cette épreuve avant d'y être autorisé.
- Rédiger un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.

**INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS**

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.

*Доорх хоёр зохиолын хэсгийг уншаад, аль нэгийг сонгон, тайлбарлаж бич. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, зохиолын төгсгөлд буй удирдамж асуултын дагуу бичиж болно.*

1. (a) Чанцал өглөөний саалиа сааж сүүгээ тушааагаад хоёр хүүгээ ундалж, гэрээсээ бүү холдоорой! гэж сайтар захиад хэдэн зуны наранд онгосон торгон дээлээ өмсөж, нэгдлийн адуунаас ноогдсон хөгшин хүрнээ эмээллэн мордов. Тийн тууварчдын буусан зүг сажлуулан явахдаа шимийн архины исгэлэн үнэрээр
- 5 амьсгаалсан гүжирмэг эрийн хажууд өнгөрүүлсэн энэ шөнийн явдлыг санаж түүний хэлсэн амласан нь үнэн болж, хүлээсэн мөрөөдсөн амьдрал нь биелбэл хаа ч явсан болно. Хоёр муу хүүгээ хүний зэрэгтэй өсгөж сургуульд оруулж бусдын цагаан гэр, хүлээн авагч, шинэ хувцас тэр бүхэнд атаархахааргүй төрсөн эс боловч эцэг гэх хүнтэй, уруу дорой царайлахгүй хийморьтой явахаар
- 10 болговол хамаг хэрэг бүтэх нь тэр. Балбар бол хүүхдэд их элэгтэй хүн юм. Бага балчирхан амьтад юундаа дасаж ядах вэ дээ гэх зэргээр олныг бодож явлаа.

Тууврын хонь мал суурь сууриараа багшран бэлчээрлэж, уулын энгэр, дэнж дээрх тууварчдын гэр майхан энд тэнд үзэгдэнэ. Голдуу майхан байх бөгөөд гэр гэвэл хоёр гурвын зэрэг ажээ. Тууварчдын зүүн жигүүрт байгаа хундан цагаан

15 гэр бол Балбарынх мөн. Чанцал гэрээс зайдуухан бууж морио тушаад баахан зүрхшээсээр гэрт оров. Нутгийн гурван харчуул ирсний нэгэнд /эрүү Дамба/ хочтой хижээл хүн. Түүний эрүү хангинуур сүхний цохилуур шиг дөрвөлжин, нүүр агуу мөртөө нүд нь жартгар, нутаг усандаа хүндгүй этгээд билээ. Хоёр дахь нь нэгдлийн туслах нягтлан бодогч залуу, хүүхэн шинжийн цэвэр царайтай

20 бөгөөд нэртэй хэрүүлч заргач хүн. Гурав дахь нь улсын заан цолтой хөх толгой хэмээх Гончиг. Балбараас дутуугүй сайхан эр бөгөөд мулгуу, цөлх хүн. Балбартай хамт яваа тууварчин бололтой нэг өвгөн байв. Түүний хувцас ядуу, царай зүс аяншиж гундсан байдалтай байжээ.

Чанцалын орж ирэхэд Балбар хэдүүл дөрвөн ханатын хоймрыг бүрхсэн хивс

25 дээр ясан даалуу тачигнуулж суулаа. Балбар, Чанцалын өөдөөс наалинхай нүдээр мишэлзэн, Ээ ашгүй, хүрээд ирэв үү. Би эднүүст нутгийн чинь хүүхнээр хонины гэдэс арчуулна гэж суулаа шүү дээ. Малын тоосонд дарагдаж яваа мань мэтэд иймэрхүү өдөр олон тохиолдох биш. За Сугар гуай хонио төхөөрөх үү дээ гэхэд

30 ядрангүй царайтай өвгөн гадагш гарч мөчийн дотор амжуулав. Чанцал хонины гэдэс янзалж хажуугийн майханд тогоо дүүрэн мах чанаж авчирсанд мань хэд ханцуй шамлан уулзав. Эрүү Дамба хаяанаас нэг лонх хар архи авч ханцуйгаараа жийрэглэн нэг цохисонд бөглөө нь бүлт үсрэн эхний хундага Балбарт зориулагдав. Цохиулах ээлжээ хүлээж байгаа лонх гэрийн хаяанд

35 жирийн хэвтэх ажээ.

Хар архинд хатгуулсан даалуучингуудын үг олширч, өгөө авааны тухай маргалдаж эхлэхэд Чанцал сэм гарч, өвгөний майханд оров. Өвгөн ч бас архинаас хувь хүртсэн тул онгод нь бяцхан орж утаа тортог болсон нөхөөст хар

40 майхны голд давшлан, - Хүүхээ наашаа суу, би чамд санаснаа хэлье. Бэлтэй чадалтай нь цагаан гэртэй, чадалгүй дорой нь хар майхантай явдаг чинь ёс шүү дээ. Энүүнд гомдох юм алга. Малын тоосонд дарагдлаа гэнэ. Чухам хэн нь дарагдаж яваа бол доо. Би Балбарт жаахан гомдох болсон доо. Танил талтай эр чадалтайдаа эрдэж хуурамч хуудуу явдалтай болж байгаа хүн. Хүн сайн явах тусмаа үнэнч болох ёстой сон. Чи жаахан бодолтой байх юм биш

45 үү гэхээр чамд падгүй гэж уурлах юм. Би бол эцгээс нь өөрцгүй хүн шүү дээ. Хүүхээ чи чинь Балбарын танил юм биз дээ. Өнгөрсөн намар хотоос нэг хүүхэн

- аваачсан. Их л эрх танхи амьтан байдаг. Өвгөний энэ яриаг дуугүй чагнаж суусан Чанцал босон харайж,
- 50 -Юу гэнээ. Балбар эхнэртэй юмуу? гэж гайхаш тасран асуугаад өвгөний хариу хэлэхээс өмнө гүйн гарав. Даалуучингуудын нэг нь "Гозгор долоо гоохолзоно, говийн хүүхэн шоохолзоно" гэж өндөр дуугаар дуудахад Балбар "Хун галуу нагал навч хурын үүл хурмастын хишиг, ясны хайртай Янжин, янагийн хайртай Чанцал татлаа татуулах уу" гэж адтай хашхирав. Нөгөө нэг нь "Нутагт байдаг Янжин, замд байдаг Чанцал" гээч хэмээн согтуурахад цөмөөрөө ха-ха-хо-хо гэж
- 55 бүдүүн нарийн дуугаар хөхрөлдөв. Чанцал бөөн хар юманд бөглөрөн давчидсан цээжээ дарж шүүрс алдаад гэрээс холдон явав.

*С.Эрдэнэ "Малын хөлийн тоос" өгүүллэг. "Шилмэл өгүүллэгүүд", 1988*

- Зохиолын агуулга, утга санаа юу вэ?
- Зохиолд гол дүрүүдийг (Балбар, Чанцал) хэрхэн дүрсэлсэн бэ? Гол дүрүүдийн зан чанарын онцлогийг тайлбарлан бич.
- Зохиолын төгсгөлд буй "Гозгор долоо гоохолзоно, говийн хүүхэн шоохолзоно" гэх мэт богино шүлгийг зохиолч ямар зорилгоор хэрэглэснийг тайлбарла.
- Энэхүү зохиолын хэсгийг уншаад танд ямар сэтгэгдэл төрсөн тухай бич.

1. (b)

- Санаа алдахад  
Эхийн сүү тагнайд амтагдаж  
Салхины үзүүр залгихад  
Агь хоолойд аргасан  
5 Боржгины бор тал минь  
Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог  
“Тэнгэрийн хэвтэр” буурал тал минь  
Таанын цагаан толгойноос өөр  
Тайтгаруулах цэцэггүй нүцгэн тал минь  
10 Нандин эрхэмсэг эгэл боргилын туйл  
Нар хур царайчилсан, газрын саальтай хормой минь
- Тэнгэр тийчиж намайг төрөхөд тал минь  
Торго шиг зөөлөн байсан чи  
Жаргал зовлон хоёрыг амсаж эдэлж  
15 Чулуун дээр чинь баяр, гунигийн нулимс унагахад  
Эр хүн шиг нуруутай бай! гэсэн шиг  
Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи  
Сайран дээр чинь өдөлсөн жигүүртэн тэнгэртээ нөгчихөд  
Салхи хөлөглөсөн өд нь чам дээр эргэж буудаг.  
20 Ботго нь үхсэн ингэний  
Борвио хагартал савирсан сүүг  
Чи л залгиж, зовлонг нь хугасалж  
Чинэсэн хөхий нь амирлуулсан.  
Чиний шарх  
25 Зүрхний шархнаас хождож анина тал минь!

*Б.Лхагвасүрэн “Боржигины бор тал”, “Уянгын тойрог”, 1982*

- Энэ зохиолд юуны тухай дүрсэлсэн бэ?
  - Зохиолын уран сайхны онцлог юу вэ? Уран дүрслэлийн ямар арга хэрэглэсэн байна вэ?
  - Энэ зохиол эх нутаг, хүн хоёрын хоорондох холбоог хэрхэн дүрсэлсэн бэ?
  - 20-25-р мөрийг уншаад уншигчид ямар сэтгэгдэл төрөх вэ?
-